ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛЫН ТӨСӨЛ

Улаанбаатар хот 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдөр

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Нялх, балчир хүүхдийн хүнсний тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. “Эхийн сүүний нөөцийн банкны үйл ажиллагааны журам”-ыг нэгдүгээр, “Эхийн сүүг сайн дураар хандивлах зөвшөөрлийн хуудас”-ыг хоёрдугаар, “Эрсдэлийн үнэлгээний хуудас”-ыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Журмыг хэрэгжүүлэхэд мэргэжил аргазүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийн газар (Б.Цэцэгсайхан), Эмнэлгийн тусламжийн бодлогын хэрэгжилтийн газар (М.Наранпүрэв), Нийслэлийн эрүүл мэндийн газар (Н.Наранбаатар), Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв (Л.Баттөр), Нийслэлийн “Амгалан” амаржих газар (Г.Мөнхзул)-д тус тус даалгасугай.

3. Журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, Эх, нярай, эмэгтэйчүүдийн эрүүл мэндийн төв – II, Аймаг, нийслэлийн амаржих газруудад үүрэг болгосугай.

4. Журмыг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг жил бүрийн төсөвт тусгахыг Санхүү, эдийн засгийн бодлогын хэрэгжилтийн газар (Л.Мөнхцэцэг), Эрүүл мэндийн даатгалын бодлогын зохицуулалтын газар (Д.Отгонбаатар), Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулах газар (Н.Эрдэнэбаяр), хүний нөөцийг сургаж чадавхжуулахад дэмжлэг үзүүлж ажиллахыг Эрүүл мэндийн хөгжлийн төв (М.Одгэрэл)-д тус тус үүрэг болгосугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (Д.Очирбат)-д даалгасугай.

САЙД Ж.ЧИНБҮРЭН

ТАНИЛЦУУЛГА

“Нялх, балчир хүүхдийн хүнсний тухай” хуулийн 15 дугаар зүйлийн “15.2. Амаржих газар, тасаг нярай хүүхдийн хоол тэжээлийг хангах зорилгоор эхийн сүүний нөөцийн банк байгуулж, ажиллуулна”, “15.3. Эхийн сүүний нөөцийн банк байгуулж, ажиллуулах журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална” гэж заасны дагуу “Эхийн сүүний банк байгуулах, ажиллуулах журам”-ын төслийг боловсруулав.

Энэхүү журмын боловсруулахдаа ДЭМБ-ын зөвлөмж, Зүүн Өмнөд Азийн бүсийн “Эхийн сүүний банкны суурь стандартууд”, Филиппин улсын Эхийн сүүний банкны удирдамж, мөн бусад холбогдох дүрэм, заавар, стандартыг үндэслэн боловсруулсан болно.

Журмын төслийг хэлэлцэх үеэр НЭМҮТ, ЭХЭМҮТ, НЭМГ, нийслэлийн амаржих газрууд, НҮБ-ын Хүүхдийн Сан, бусад холбогдох төрийн болон хувийн хэвшлийн төрөх эмнэлэг, байгууллагын санал, зөвлөмжийг тусгасан болно.

2025.12.01-ний өдрөөс 12.05-ны өдрүүдэд “Эхийн сүүний банк” (Human Milk Bank, HMB) байгуулах бэлтгэл ажлыг хангах хүрээнд Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсын Да Нанг хотын Хүүхэд, Эмэгтэйчүүдийн эмнэлэгт туршлага судлан, сургалтад ЭХЭМҮТ, нийслэлийн Хүрээ амаржих газрын удирдлага, нярайн эмч, мэргэжилтэн нар хамрагдан журмын төслийг эцэслэн боловсруулаад байна.

Донор эхийн сүү нь дутуу болон бага жинтэй төрсөн, өвчтэй нярай, эсвэл эрүүл мэндийн шалтгаанаар эхийн сүүгээр хооллох боломжгүй болон эхийн сүү хангалтгүй тохиолдолд нярайн өвчлөл, эндэгдлийг бууруулах зорилгоор хэрэглэх зориулалттай юм.

--- o0o ---

Эрүүл мэндийн сайдын
2025 оны ..... дугаар сарын ..... ны өдрийн
.... дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

ЭХИЙН СҮҮНИЙ НӨӨЦИЙН БАНКНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

Нэг. Үндэслэл

Эхийн сүү нь нярай хүүхдэд хамгийн тохиромжтой, юугаар ч орлуулшгүй хоол тэжээлийн эх үүсвэр бөгөөд уураг, амин дэм, дархлааны амьд эс болон шим тэжээлийн төгс тэнцвэртэй найрлагыг агуулдаг. Эхийн сүү нь нярай хүүхдийг эрүүл чийрэг өсч бойжих, дархлаа тогтолцоо бүрэлдэх, улмаар өсөлт хөгжлийг хэвийн явагдахад чухал ач холбогдолтой. Эхийн сүүгээр хооллох нь хүүхдийг халдварт болон халдварт бус өвчлөл, мөн хоол тэжээлийн дутлаас сэргийлэхэд өндөр ач холбогдолтой. Ялангуяа дутуу төрсөн, бага жинтэй болон төрөлхийн өвчин эмгэгтэй нярайд эхийн сүү нь өвчлөл, эндэгдлээс сэргийлэхэд онцгой үр нөлөөтэй байдаг.

ДЭМБ-аас эхийн сүүгээр хооллох нь тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг 13 хүртэлх хувиар, нярайн эндэгдлийг 33 хүртэлх хувиар бууруулж, эхэд хөхний хавдраар өвчлөх эрсдлийг жил бүр 6 хувиар багасган, хөхний хавдартай холбоотой нас баралтаас сэргийлэх боломжтой хэмээн тодорхойлсон..

Эхийн сүү нь 0-5 сартай хүүхдэд шаардлагатай илчлэг болон шимт бодисыг хангалттай хэмжээгээр агуулдаг тул нялх хүүхдийг амьдралын эхний 6 сар хүртэл зөвхөн эхийн сүүгээр дагнан хооллох ба хүүхэд 6 сартай болмогц эхийн сүүгээр хооллохын зэрэгцээ насанд нь тохирсон нэмэгдэл хоол өгөхийг зөвлөдөг. Эхийн сүүг 2 нас хүртэл, боломжтой бол түүнээс дээш хугацаанд ч эхийн сүүгээр үргэлжлүүлэн хооллохыг дэмждэг. Төрөх эмнэлгүүдэд эхийн сүүний нөөцийн банк байгуулж, түүний үйл ажиллагааг дэмжих нь нярайн өвчлөл, эндэгдлийг бууруулахад чухал ач холбогдолтой юм.

Донор эхийн сүү нь өөрийн эхийн сүүгээр хооллох боломжгүй эсвэл хангалтгүй байгаа дутуу болон бага жинтэй төрсөн нярай, өвчтэй нярай эсвэл эмнэлзүйн заалттай нярайд хэрэглэх зориулалттай ба сүү хандивлагчдыг бүртгэх, сүүг хүлээн авах, шинжлэх, боловсруулах, хадгалах, түгээх үйл ажиллагааны аюулгүй, тасралтгүй байдлыг хангахыг энэхүү журмаар зохицуулна.

Хоёр. Үйл ажиллагааны зарчим

2.1. Энэхүү журам нь Нялх, балчир хүүхдийн хүнсний тухай хуулийн 15 дугаар зүйлийг үндэслэн нярай хүүхдийн хоол тэжээлийн хэрэгцээг хангах, эрүүл мэндийг хамгаалах зорилгоор төрөх, амаржих газар болон нярайн тасгуудад

эхийн сүүний нөөцийн банк байгуулах, түүний үйл ажиллагааг зохион байгуулахтай холбоотой харилцааг зохицуулна.

2.2. Эхийн сүүний нөөцийн банк нь төрөх үйл ажиллагаа явуулдаг төрийн ба хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлж буй хөхүүл эхчүүдээс донор эхийг элсүүлэх, эхийн сүүг хандив болгон хүлээн авах, шинжлэх, боловсруулах, хадгалах, түгээх, хэрэглэх үйл ажиллагааг удирдан зохион байгуулах үүрэгтэй.

2.3. Эхийн сүүний нөөцийн банк нь салбар нэгжүүдтэй байх бөгөөд салбар нэгжүүд нь донор эхийг бүртгэх, хандивласан сүүг шинжилгээнд хамруулах, ариутгахын тулд төв банк руу тээвэрлэх, ариутгасан сүүг буцаан хүлээн авч түгээх үүрэгтэй.

2.4. Эхийн сүүгээр хооллолтыг дэмжих, сурталчлах, хамгаалах нь эхийн сүүний нөөцийн банкны үйл ажиллагааны үндсэн зарчим байна.

2.5. 2000 граммаас доош жинтэй төрсөн нярайн 80-аас доошгүй хувьд Имж эх асаргааг тогтмол хэрэгжүүлдэг эрүүл мэндийн байгууллага нь эхийн сүүний нөөцийн банк болон салбар нэгж байгуулна.

2.6. Донорын сүүний хэрэглээ нь түр хугацааны хэрэглээ бөгөөд зөвхөн эхийн сүү хангалттай ороогүй байгаа үед түр хугацаанд өгнө.

2.7. Донор эх элсүүлэх, бүртгэх, сүү хандивлах үйл явц нь сайн дурын үндсэн дээр, хүмүүнлэг, хүний эрхийг хүндэтгэсэн, хувь хүний мэдээллийн нууцыг хадгалах зарчимд тулгуурлана.

2.8. Эхийн сүүний нөөцийн банк нь ашгийн бус зарчмаар ажиллана.

2.9. Эхийн сүүний нөөцийн банкны үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангахын тулд санхүүжилтийг тооцож, жил бүрийн төсөвт тусган эрүүл мэндийн даатгалын сантай холбоно.

Гурав. Нэр томьёо, тодорхойлолт

3.1. Эхийн сүүний нөөцийн банк: Хөхүүл эхчүүдээс эхийн сүүг сайн дурын үндсэн дээр хандив болгон хүлээн авч, цуглуулан, ангилан, чанарын хяналт хийж, боловсруулан, хадгалж, түгээх үйл ажиллагааг хэрэгжүүлдэг; хөхөөр хооллох боломжгүй эсвэл эхийн сүү хангалтгүй байгаа хүүхдийг эхийн сүүгээр хангах үүрэгтэй эрүүл мэндийн байгууллагын бүтцийн нэгж;

3.2. Эхийн сүүний нөөцийн банкны салбар нэгж: Төрөх үйл ажиллагаа явуулдаг төрийн ба хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагад байрлан донор эхийн сүүг хүлээн авч, бүртгэж, хадгалан эхийн сүүний нөөцийн төв банк руу илгээх, төв банкнаас ариутгасан донор эхийн сүүг хүлээн авч нярайн хэрэглээнд түгээх, түгээлт хэрэглээний бүртгэл хөтлөх үйл ажиллагааг зохион байгуулдаг бүтцийн нэгж;

3.3. Эхийн саасан сүү: Төрсний дараа хөхүүл эмэгтэйн хөхнөөс сааж авсан, боловсруулалт хийгдээгүй, шим тэжээл болон биологийн идэвхт бодис агуулсан тэжээллэг шингэн;

3.4. Донор эх: Эхийн сүүгээ сайн дурын үндсэн дээр хандивласан эмэгтэй;

3.5. Донор эхийн сүү: Эхийн сүүний нөөцийн банканд хөхүүл эхчүүдийн сайн дурын үндсэн дээр хандивласан, зориулалтын аргаар боловсруулан хадгалсан эхийн сүү;

3.6. Эхийн хөргөөсөн сүү: Эхийн саасан сүүний бичил биетийн үржлийг хязгаарлах зорилгоор 4±2^{O}C хэмд хөргөгчид хадгалсан сүү;

3.7. Эхийн хөлдөөсөн сүү: Эхийн саасан сүү эсвэл пастеризац хийсэн сүүг **с**үүний найрлагын тогтвортой байдлыг хадгалах зорилгоор -20^{O}C ба түүнээс доош хэмд хөлдөөгчид хадгалсан сүү;

3.8. Дулаанаар ариутгасан /пастеризац хийсэн/ эхийн сүү: Эхийн сүүг 62.5^{O}C (±0.5^{O}C) хэм хүртэл халааж, биологийн шинж чанарыг нь хадгалан, бичил биетийн тоог хүний эрүүл мэндэд аюулгүй түвшинд бууруулсан сүү;

3.9. Багц: Пастеризац хийсэн эсвэл хийгээгүй сүүг нэгтгэн савласан нэгж;

3.10. Микробиологийн шинжилгээний сорьц: Сүүний багцын төлөөлөхүйц хэсгээс санамсаргүй аргаар авсан, бичил биетийн тоо болон чанарыг шалгах зориулалтын сорьц;

3.11. КҮН-колони үүсгэгч нэгж: Бичил биетийн тоог илэрхийлэх нэгж;

3.12. Чанарын хяналт: Эхийн сүүний нөөцийн банкны үйл ажиллагаанд ашиглагдах сүүний шинжилгээ, бичил биетийн тоо, пастеризацийн үр дүн, хадгалалт, түгээлтийн үйл явцад тавих хяналт;

Дөрөв. Эхийн сүүний нөөц бүрдүүлэх үе шатууд

Эхийн сүүний нөөцийг бүрдүүлэх үйл ажиллагаа нь дараах 3 үе шаттай. Үүнд:

I. Донор эхийг элсүүлэх ба донор эхийн сүүг цуглуулах
II. Донор эхийн сүүг боловсруулах ба хадгалах
III. Донор эхийн ариутгасан сүүг түгээх ба ашиглалтын хяналт

4.1. Донор эхийг элсүүлэх ба донор эхийн сүүг цуглуулах

4.1.1. Донор эхийг дараах бүлгийн эхчүүдээс элсүүлнэ. Үүнд:

- тухайн эрүүл мэндийн байгууллагад амаржсан, сүүний гарц сайтай эхчүүд;
- тухайн эрүүл мэндийн байгууллагын нярайн тасагт хэвтэн эмчлүүлж буй нярай хүүхэдтэй эхчүүд;
- тухайн эрүүл мэндийн байгууллагад ажилладаг 2 нас хүртэлх настай хүүхэдтэй хөхүүл эхчүүд;
- сүүний гарц сайтай 12 сар хүртэлх настай хүүхэдтэй болон эхийн сүүний банкны үйлчилгээ авах боломжтой эхчүүд;

4.1.2. Сүүгээ хандивлахыг сайн дурын үндсэн дээр зөвшөөрсөн 18 нас ба түүнээс дээш насны эхчүүдийн эрсдлийн үнэлгээг хавсралт №3-ын дагуу үнэлнэ.

4.1.3. Донор эхийн бүртгэлийг холбогдох дүрэм, журмын дагуу бүртгэж, архивлан хадгална.

4.1.4. Эхийн сүүний донороор сонгогдсон эхчүүд нь "Эхийн сүү хандивлах зөвшөөрлийн хуудас"-т гарын үсэг зурж баталгаажуулна.

4.1.5. Донор эхэд хөхөө саах, сүүгээ хадгалахад баримтлах эрүүл ахуйн дэглэмийн талаар мэдлэг олгож, зааварчилгаа өгнө. Сүүний гарц нь тухайн эх өөрийн хүүхдийн хэрэгцээг хангахын зэрэгцээ донорын сүү хандивлахад хангалттай байхыг анхааруулан хэлнэ. Эхчүүд хөхөө гараар саах нь чухал ур чадвар тул төрсний дараа аль болох эрт хугацаанд хөхөө саахыг зөвлөнө.



4.1.6. Сүү хандивлаж буй хугацаанд донор эхийн эрүүл мэндийн байдал, хэрэглэж буй эм, аливаа эрсдлийг үнэлэх зорилгоор 3 сар тутамд хавсралт №3-ын хоёр дахь асуумжийн дагуу ярилцлага хийж үнэлнэ.

4.1.7. Донор эхийн сүү хандивлах үйл ажиллагааг дараах тохиолдолд түр зогсооно. Үүнд:

- хэрэв хавсралт №3-ын хоёр дахь асуумжийн аль нэг асуултад “Тийм” гэж хариулсан;
- ХДХВ, гепатитын В, С вирус, тэмбүүгийн шинжилгээний аль нэг эерэг гарсан;

- хөхүүл эх эсрэг заалттай ямар нэг эм, бодис хэрэглэж байгаа; хөх үрэвссэн эсвэл хөх орчмын арьс, зөөлөн эдэд эмгэг өөрчлөлт илэрсэн;
- хүүхэд эмнэлгээс гарч эх нь сүүгээ хандивлах боломжгүй болсон;
- донор эх өөрийн хүсэлтээр сүү хандивлахаа зогсоох хүсэлт гаргасан;

4.1.8. Хэрэв сүүгээ хандивлахаар төлөвлөж буй эх хуурай ханиалгах, халуурах (37^{O}C-ээс дээш), ханиад томууны шинж илэрч байвал шинж тэмдэг арилснаас хойш дор хаяж 7 хоногийн дараа сүүгээ хандивлах боломжтой.

4.1.9. Эхийн сүүтэй харьцаж байгаа эрүүл мэндийн ажилтнууд гараа угааж, халдвар хамгааллын шаардлагыг хангаж ажиллана. Үүнд: эмнэлгийн халад, малгай, үсний тор, амны хаалт, бээлий өмсөнө.

4.1.10. Донор эхчүүдэд сүүгээ гараар болон хөхний саалтууруар саах арга, сүү хадгалах үеийн эрүүл ахуйн дэглэмийг зааж, зааварчилгаа өгнө.

4.1.11. Донор эхийн сүүтэй харьцсан бүх тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг зааврын дагуу цэвэрлэж, халдваргүйжүүлж, ариутгана.

4.1.12. Донор эхийн сүүг хадгалах хэсэг, сүү боловсруулах өрөө, сүү хүлээн авах хэсгийн гадаргууг халдвар хамгааллын дүрэм, журмын дагуу цэвэрлэж, халдваргүйжүүлнэ.

4.1.13. Зориулалтын хөхний саалтуур, цэвэр сав, суулга, зөөврийн хүйтэн хэлхээний цүнх эсвэл зөөврийн хөргөгч, тээврийн хэрэгслийн бэлэн байдлыг хангана.

4.1.14. Донор эхчүүдэд гараар болон хөхний саалтуур ашиглан саасан сүүгээ хадгалах зориулалтын уут, савыг олгоно.

4.1.15. Эхийн сүүг цуглуулах, хадгалах савууд нь хүнсний зориулалтын, аюулгүй, цэвэрлэхэд хялбар, удаан эдэлгээтэй, бисфенол А (BPA) агуулаагүй байх шаардлагатай. Хатуу хуванцар сав, полиэтилен уут, шилэн сав ашиглаж болно. Мөн цилиндр хэлбэртэй, өргөн амсартай, эргэдэг тагтай, зэвэрдэггүй ган савыг ашиглах боломжтой.

4.1.16. Сүүгээ саасны дараа аль болох хурдан 5-10 минутын дотор хөргөгчид хийнэ. Саасан сүүг 30 минут болон түүнээс дээш хугацаагаар өрөөний хэмд байлгахыг хориглоно. Хэрэв эх сүүгээ саахад сүү хадгалах сав дүүрч байвал шууд хөлдөөгчид хийж болно. Хэрэв сав дүүрэхгүй бол хөргөгчид хадгалж цуглуулна.

4.1.17. Хөргөгчид хадгалсан сүүг 24 цагийн дотор цуглуулж нэг багц болгоод хөлдөөгчид хийж хөлдөөнө. Хэрэв хөлдөөсөн савтай сүүний хэмжээ бага бол дээр нь сүү нэмж болно. Гэхдээ нэмж хийх сүүгээ хөргөгчид хөргөсний дараа тухайн 24 цагийн багцад багтаж байвал хөлдүү сүүн дээр нэмж болно. Хадгалсан сүүнүүд ижил хэмжээтэй байна. Хэрэв хөргөгчид цуглуулсан 24 цагийн хугацаанд сав дүүрээгүй бол бага хэмжээгээр нь хөлдөөнө.

Сүү хөлдөх үед тэлэлт үүсдэг тул савыг нийт багтаамжийн 3/4 хүртэл дүүргэнэ. Шошгонд хамгийн эхэлж саасан сүүний огноо, цаг, минутыг арилахгүйгээр тодорхой бичнэ.

4.1.18. Саасан бүх сүүний савны шошгонд дараах мэдээллийн заавал бичнэ. Үүнд: донор эхийн нэр эсвэл хувийн (ID) дугаар, саасан огноо, цаг, минут, сүү саахаас өмнөх 24 цагийн дотор хэрэглэсэн эмийн нэр г.м.

4.1.19. Саасан сүүг хөргөгчид 24 цагаас удаахгүй хадгалсны дараа, хөлдөөгчид шилжүүлж хадгална.

4.1.20. Донор эхчүүдэд гэрийн нөхцөлд сүүгээ саах болон саасан сүүгээ хадгалах талаар тогтмол зааварчилгаа өгч, хяналт тавина. Донор эхчүүд нь гэрийнхээ хөргөгч, хөлдөөгчийн хэмийг тогтмол шалгаж тэмдэглэл хөтөлж байвал зохино. Хэрэв гэртээ термометргүй бол төхөөрөмж хэвийн ажиллаж байгаа эсэхийг тэмдэглэнэ. Гэрийн эргэлтийн үед эхийн сүүний банкны ажилтан хөргөгч, хөлдөөгчийн хэм, хадгалалтын нөхцөлийг шалгана.

4.1.21. Саасан сүүтэй савыг хөргөгчний хаалганд байрлуулахгүй, харин хөргөгчний хамгийн хүйтэн хэсэгт (ихэвчлэн доод тавцангийн арын хэсэгт) хадгална.

4.1.22. Саасан сүүг зориулалтын цэвэр полиэтилен уут эсвэл хуванцар саванд хийж хадгална.

4.1.23. Эхийн сүүний банкны ажилтнууд донор эхчүүдтэй тогтмол холбогдож дэмжлэг үзүүлэх бөгөөд саасан сүүгээ эхчүүд өөрсдөө сүүний банканд авчирч өгөх эсвэл эрүүл мэндийн ажилтнууд гэрээс очиж цуглуулна.

4.1.24. Эхийн саасан сүүг тээвэрлэхдээ битүүмжилсэн сав, баглаа боодол ашиглан тээвэрлэнэ. Хөргөөсөн болон хөлдөөсөн эхийн сүүг зориулалтын, хатуу хана бүхий дулаан тусгаарлагчтай зөөврийн хүйтэн хайрцагт хийж тээвэрлэнэ. Зөөврийн хүйтэн хайрцагны шошгонд хайрцган доторх зүйлсийн мэдээлэл, хүргэх газрын хаягийг бичих ба сүүг хүргэсний дараа нэн даруй хөргөгч эсвэл хөлдөөгчид хийх шаардлагатайг тэмдэглэнэ.

4.1.25. Эхийн сүүг тээвэрлэхдээ 1 цагаас дээш хугацаанд тээвэрлэхээр бол хөлдөөсөн мөс ашиглахгүй, зөвхөн хөлдөөсөн гелэн хөргүүр ашиглана. Бага хэмжээний сүү тээвэрлэж буй тохиолдолд савны хоосон зайг цаас, алчуур эсвэл хөлдөөсөн гелиэр дүүргэж тогтвортой хэмийг хадгална.

Тээвэрлэлтийн дараа сүүний хэмийг бүртгэнэ.

3.1.26. Донорын саасан сүү болон пастеризац хийсэн сүүг хадгалах нөхцөл:

Хадгалах нөхцөл	Хадгалах хэм	Хадгалах хугацаа		Тайлбар
		Донорын саасан сүү	Пастеризац хийсэн донорын сүү	
Өрөөний хэм	16 - 30 °C	Саасны дараа шууд хөргөгч/хөлдөөг-чид хийх	3 – 4 цаг	Сүүний хадгалалтыг хадгалж эхэлсэн эхний цаг минутаас тооцох
Гэрийн хөргөгч	8 - 15 °C	12 цаг	12 цаг	
Гэрийн хөлдөөгч	≤ -15°C	2 долоо хоног	2 долоо хоног	
Эхийн сүүний банкны хөргөгч	≤ +4°C	24 цагийн дотор пастеризац хийх эсвэл хөлдөө ж хадгалах	24 цагийн дотор гэсгээж, хуваах	

Э хийн сүүний банкны хөлдөөгч	≤ -20°	С үүг сааснаас хойш 3 сарын дотор пастеризац хийх	Сүүг сааснаас хойш 6 сарын дотор хэрэглэх	Сааснаас хойших хамгийн эхний өдрөөс тооцох

4.2. Донор эхийн сүүг боловсруулах ба ариутгах

4.2.1. Эхийн сүүний нөөцийн банканд хүргэгдэж ирсэн донор эхийн сүүг гүн хөлдөөгчид - 20^{O}C хэм болон түүнээс доош хэмд хадгална.

4.2.2. Пастеризац хийхийн өмнө хөлдөөсөн сүүг бүрэн гэсгээсэн байх шаардлагатай. Сүү бүрэн гэссэн тохиолдолд пастеризац жигд хийгддэг. Хөлдөөсөн сүүг хөргөгчид ≤ 4^{O}C хэмд 24 цагийн турш байлгаж аажим гэсгээнэ. Гэсгээснээс хойш 24 цагийн дотор пастеризац хийнэ.

4.2.3. Сүүг гэссэний дараа тасалгааны хэмд байлгах хугацааг аль болох богино байлгана. Сүүний температурыг 7^{O}C хэмээс дээш болгохоос зайлсхийнэ.

4.2.4. Сүүг богино долгионы зууханд гэсгээхийг хориглоно. Гэсгээсэн сүүг дахин хөлдөөж болохгүй**.**

3.2.5. Хөлдөөсөн түүхий сүүг саасан өдрөөс хойш гурван сарын дотор пастеризацын аргаар ариутгана.

4.2.6. Сүүг пастеризац хийх үедээ халдвар хамгааллын дэглэм болон үйл ажиллагааны протоколыг чанд баримтлана.

4.2.7. Пастеризац хийхийн өмнө бүрэн гэссэн сүүг нэг том саванд хийж, сүүний тослог жигд холилдох хүртэл зөөлөн хутгана.

4.2.8. Сүүг ламинар урсгалтай кабинд нэгтгэнэ. Хэрэв кабин байхгүй бол салхивч, агааржуулагчийн шууд урсгалаас хол, цэвэрлэхэд хялбар, зэвэрдэггүй ган гадаргуутай хэсэгт нэгтгэнэ.

4.2.9. Пастеризац хийхдээ зөвхөн нэг донор эхийн сүүг нийлүүлэн боловсруулна.

4.2.10. Сүүг хольж нийлүүлсний дараа пастеризацын савуудад ижил хэмжээтэй хувааж хийнэ. Сав бүрт ижил хэмжээтэй сүү хийх нь пастеризацын явцад дулааны боловсруулалт жигд явагдах нөхцлийг бүрдүүлнэ.

4.2.11. Сүүтэй сав бүрт шошго наана. Шошгон дээр дараах мэдээллийг бичнэ. Үүнд: донор эхийн ID дугаар, сүү саасан огноо, пастеризац хийсэн огноо, хадгалах хугацаа/дуусах огноог бичнэ.

4.2.12. Сүүний нянгийн тоо зөвлөмж хэмжээнээс хэтэрсэн үед тухайн сүүг шаардлага хангаагүй гэж үзээд устгалд оруулна.

4.2.13. Сүүг пастеризац хийхдээ 62.5^{O}C (±0.5^{O}C) хэм хүртэл халааж энэ хэмдээ 30 минут барина. Пастеризац хийж дууссаны дараа сүүг хурдан хугацаанд 4^{O}C хүртэл хөргөнө.

4.2.14. Пастеризацийн бүртгэлд сүүний багцын дугаар болон пастеризацийн мөчлөгийг тэмдэглэн, гарын үсэг зурж баталгаажуулна. Мэдээллийг 10 жилийн хугацаанд архивлан хадгална. Хэрэв пастеризацийн хэм болон хугацааны үзүүлэлт

шаардлага хангаагүй бол эхийн сүүний банкны ахлагчид мэдээлэх ба зөвшөөрөл өгөхөөс өмнө тухайн сүүг хэрэглэхийг хориглоно.

4.2.15. Пастеризац хийсний дараа сүүний багц бүрээс төлөөлөхүйц дээж авч нян судлалын шинжилгээ хийнэ.

4.2.16. Дараах 3 төрлийн сүүг тус тусад нь хадгалахын тулд доод тал нь 3 тусдаа хөлдөөгч шаардлагатай. Үүнд: I) пастеризац хийгээгүй сүү, II) микробиологийн шинжилгээний хариу хүлээж буй пастеризац хийсэн сүү, III) шинжилгээгээр тэнцсэн пастеризац хийсэн сүү

4.2.17. Шинжилгээний хариу гарсны дараа шалгуур хангаагүй сүүг хөлдөөгчөөс гаргаж устгалд оруулна. Шинжилгээнд тэнцсэн сүүг ≤-20°C хэм ба түүнээс хүйтэн хэмтэй хөлдөөгчид хадгална.

4.3. Донорын сүүг түгээх ба хэрэглээг зохицуулах

4.3.1. Эхийн сүүний нөөцийн банк нь бусад эмнэлгүүдээс болон салбар нэгжээс ирсэн захиалгыг хүлээн авах зохицуулалттай байна.

4.3.2. Пастеризац хийсэн донорын сүүг хамгийн эрт хөлдөөсөн хугацаанаас эхлэн олгоно.

4.3.3. Пастеризац хийгээд хөлдөөсөн сүүг гэсгээсний дараа 24-48 цагийн дотор хэрэглэнэ. Хэрэглээгүй тохиолдолд гэсгээсэн сүүг устгалд оруулна.

4.3.4. Эхийн сүүний нөөцийн банкны сүүг хэрэглэх үндсэн заалт:

- Дутуу нярай (Prematurity)
- Хоол тэжээлийн шимэгдэл алдагдал (Malabsorption)
- Хоол тэжээлийг тэсвэрлэх чадваргүй байдал (Feeding intolerance)
- Дархлаа дутмагшил (Immunologic deficiencies)
- Төрөлхийн хөгжлийн гажиг (Congenital anomalies)
- Мэс заслын дараах байдал (Post-operative surgical conditions)

4.3.5. Донорын сүүний нөөц хангалттай байгаа тохиолдолд эмчийн заалтаар олгоно. Үүнд:

- Хооллолтын бэрхшээл эсвэл эхийн сүү хангалтгүй байгаа
- Үрчилж авсан хүүхэд
- Эхийн өвчний улмаас хүүхийг түр хугацаанд хөхүүлэх боломжгүй болсон тохиолдол
- Төрүүлсэн эхийн хөхний сүүг хэрэглэх нь нярайд эрүүл мэндийн эрсдэл үүсгэж болзошгүй тохиолдол
- Эх нас барсан
- Хүүхдэд нэмэлт тэжээл өгөх шаардлагатай тохиолдол
- Эх өөрийн хөхний сүүгээр хооллох боломжгүй шалтгаан: эх өвчтэй байх, химийн болон туяа эмчилгээтэй, эх нас барсан, нярай хүүхдээсээ татгалзсан буюу орхиж явсан зэрэг болно.

4.3.6. Донор эхийн сүүг захиалах дараалал:

1. нярайн төрсөн жин < 1500 гр эсвэл тээлтийн хугацаа < 32 долоо хоногтой дутуу нярай

2. зүрхний төрөлхийн хөгжлийн гажигтай нярай
3. хүнд өвчтэй эсвэл мэс заслын дараах тохиолдол
4. өвчин эмгэггүй дутуу төрсөн эсвэл бага жинтэй төрсөн нярай
5. өвчин эмгэггүй гүйцэд төрсөн нярай
6. тусгай эмнэлзүйн заалттай 6 сар хүртэлх настай хүүхэд (хавдар, дархлаа дутмагшил, зүрхний өвчин, хоол боловсруулах тогтолцооны эмгэг гэх мэт)
7. эмчийн заалтаар төрсний дараах эхний өдрүүдэд эхийн сүү хангалтгүй байгаа эрүүл нярай

4.3.7. Нярайд донор эхийн сүү өгөх талаар эх, эцэг эсвэл хууль ёсны асран хамгаалагч нарт мэдээлэл өгч, зөвшөөрөл авна.

4.3.8. Нярайн эмч донор эхийн сүүг хэрэглэх заалт, өгөх хэмжээ, үргэлжлэх хугацаа, давтамж зэргийг тодорхой бичнэ.

Тав. Эхийн сүүний нөөцийн банкны үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалт

5.1. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

5.1.1. Улсын хэмжээнд эхийн сүүний нөөцийн банк болон салбар банк байгуулах шалгуур үзүүлэлтийг гаргах

5.1.2. Эхийн сүүний нөөцийн банкны үйл ажиллагаа болон санхүүжилттэй холбоотой эрх зүйн баримт бичгийг боловсруулах, шаардлагатай тохиолдолд нэмэлт өөрчлөлт оруулах

5.1.3. Эхний сүүний нөөцийн банкны зохион байгуулалт, үйл ажиллагааны үр дүн, чанар, гүйцэтгэл болон зардлын үр ашгийн хэрэгжилтэд хяналт тавих;

5.1.4. Эрүүл мэндийн байгууллагын ажилтнуудыг мэргэжлийн удирдлага, зохион байгуулалтаар хангах

5.1.5. Эрүүл мэндийн байгууллагын ажилтнуудыг чадавхжуулах болон үр чадварыг дээшлүүлэх сургалтад хамруулах

5.1.6. Эхийн сүүний нөөцийн банкны үйл ажиллагаанд мэдээллийн технологи, өгөгдлийн шинжилгээ, мэдээллийн сангийн менежментийг нэвтрүүлэх

5.2. Нийслэлийн эрүүл мэндийн газар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

5.2.1 Нийслэлийн хэмжээнд эхийн сүүний нөөцийн банкны үйл ажиллагааг тогтвортой, үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд бодлого, зохицуулалт, зохион байгуулалт, салбар хоорондын хамтын ажиллагааг зохицуулах, үр дүн чанарын үзүүлэлтийг хянах, үнэлэх

5.2.2 Нийслэлийн эрүүл мэндийн байгууллагуудаас цуглуулсан мэдээлэлд үндэслэн нутаг дэвсгэр дэх донор эхийн сүүний жилийн хэрэгцээг тооцоолох, нөөц төлөвлөлтөд ашиглах

5.2.3. Эхийн сүүний нөөцийн банкны үйл ажиллагаанд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх, шаардлагатай дүрэм, журамд нэмэлт өөрчлөлт оруулах санал боловсруулах, хэрэгжилтэд зөвлөмж өгөх

5.2.4. Эхийн сүү хандивлахын ач холбогдол, донорын сүүний аюулгүй байдал, хэрэглээний үр дүнг олон нийтэд сурталчлах, мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх

5.2.5. Эхийн сүүний нөөцийн банк, донор эх, нярайн эрүүл мэндийн чиглэлээр судалгаа, тандалт, статистик мэдээлэлийг цуглуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх, тайланг Эрүүл мэндийн яаманд хүргүүлэх

5.3. **Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв** дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

5.3.1. Эхийн сүүний нөөцийн банкны хэрэгцээ, донор эхийн хүртээмж, нярайн өвчлөл ба хүндрэлтэй холбоотой судалгаа, тандалт, статистик мэдээллийг цуглуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх, нотолгоонд суурилсан зөвлөмж боловсруулж Эрүүл мэндийн яаманд хүргүүлэх

5.3.2. Эхийн болон донорын сүүтэй холбоотой тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын үндэсний стандарт, заавар, удирдамжийг боловсруулах, шинэчлэхэд мэргэжлийн дэмжлэг үзүүлэх

5.3.3. Эхийн сүү хандивлах, цуглуулах, нөөцлөх, пастеризац хийх, хуваарилах үйл ажиллагаанд мөрдөх эрүүл ахуй, халдвар хяналтын зөвлөмжийг боловсруулж хэрэгжилтэд мэргэжлийн зөвлөгөө өгөх

5.3.4. Эхийн сүүний нөөцийн банкны ажилтнууд, донор эхтэй харилцагч мэргэжилтнүүд болон нярайн тусламж үйлчилгээний ажилтнуудад зориулсан сургалтын хөтөлбөр, сургалтын материал, гарын авлага боловсруулах, сургалт зохион байгуулах

5.3.5. Эхийн сүү хандивлахын ач холбогдол, пастеризац хийсэн донорын сүүний эрүүл мэндийн үр нөлөө, аюулгүй байдлын талаар олон нийтэд чиглэсэн мэдээлэл, сурталчилгааны үйл ажиллагааг зохион байгуулах

5.3.6. Эхийн сүүний нөөцийн банкны хяналт-шинжилгээ, үнэлгээ тогтолцоог боловсруулж, хэрэгжилтийг хангуулах, чанарын үзүүлэлт, стандартын хэрэгжилтийг хянах, сайжруулах зөвлөмж гаргах

5.3.7. Донорын бүртгэл, сүүний боловсруулалт, чанарын хяналт, нөөцийн хөдөлгөөнтэй холбоотой мэдээллийн нэгдсэн системийг хөгжүүлэх, өгөгдлийн аюулгүй байдлыг хангах, үндэсний түвшний мэдээллийн сан бүрдүүлэх

5.3.8. Эхийн сүүний нөөцийн банкны үйл ажиллагааг бодлого, зохицуулалтын түвшинд дэмжих, холбогдох дүрэм, журамд нэмэлт өөрчлөлт оруулахад шаардлагатай мэргэжлийн дүгнэлт, санал боловсруулж Эрүүл мэндийн яаманд хүргүүлэх

5.4. **Эх, нярайн тусламж үйлчилгээ үзүүлдэг эрүүл мэндийн байгууллагууд** дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

5.4.1. Эрүү мэндийн байгууллага нь тухайн эмнэлгийн даргын тушаалаар эхийн сүүний нөөцийн банк эсвэл салбар нэгжийн багийг байгуулж, үйл ажиллагааны журмыг боловсруулах

5.4.2. Эхийн сүүний нөөцийн банкны үйл ажиллагааг лаборатори, ариутгал, оношилгооны болон бусад эмчилгээний тасгуудтай уялдуулан зохицуулж, хамтын ажиллагааны орчныг бүрдүүлэх

5.4.3. Эхийн сүүний донорыг илрүүлэх, сонгох, элсүүлэх үйл ажиллагааг холбогдох журмын дагуу зохион байгуулах, нярайн тасгийн чадавхыг бэхжүүлэх, шаардлагатай хүний нөөцийн асуудлыг зохицуулах

5.4.4. Эхийн сүүг цуглуулах, нөөцлөх зориулалтын өрөөг хоолны газар, ариун цэврийн өрөө, халдварт өвчний тусгаарлах өрөө зэрэг бохирдол, халдварын эх үүсвэрээс тусгаарлан, цэвэр, хуурай, агааржуулалт сайтай, үйлчлүүлэгч бүхий тасаг нэгжтэй ойр байршуулах

5.4.5. Эхийн сүүг цуглуулах, нөөцлөх өрөөг хөргөгч, хөлдөөгч, сүү ариутгагч төхөөрөмж, сав угаагч, ариутгагч, хатаагч, термометр, дохиолол болон бусад шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах

5.4.6. Эхийн сүүний донорыг сонгох, донорын сүүтэй харьцах болон донорын гэр бүлтэй харилцах ажилд оролцдог эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг тасралтгүй сургах, дадлагажуулах, мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулах

5.4.7. Эхийн сүүний донор сонгох, эхийн сүүг цуглуулах, нөөцлөх, хэрэглэх үйл ажиллагаанд мөрдөх стандарт, чанарын хяналт, дотоод аудит, үйл ажиллагааны зааврыг боловсруулж, байгууллагын даргын тушаалаар баталж хэрэгжүүлэх

4.4.8. Эхийн сүүний донорын бүртгэл болон үйл ажиллагааны талаарх нэгдсэн мэдээллийн бүрдүүлж, хөтлөн баяжуулж, холбогдох мэдээ тайланг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тогтмол хүргэх

5.5. Эхийн сүүний нөөцийн банкны баг дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

5.5.1. Эхийн сүүний нөөцийн банк нь тухайн эмнэлгийн удирдлагын багтай байнгын хамтын ажиллагаатай ажиллах;

5.5.2. Эхийн сүүний донорын сургалт, мэдээлэл сурталчилгаа, сайн дурын ажилтан бэлтгэх, донор эх элсүүлэх, сонгох, сүү цуглуулах үйл ажиллагааг мэргэжил арга зүйгээр хангах;

5.5.3. Донор эхээс сүү цуглуулах үйл явцад эрүүл ахуйн зохистой дадлыг нэвтрүүлж, чанарын зорилт, шалгуур үзүүлэлтийн хэрэгжилт, аюулгүй ажиллагааг хангах;

Зургаа. Эрүүл мэндийн байгууллагын баримтжуулалт

6.1. Эрүүл мэндийн байгууллагууд эхийн сүүний нөөцийг цуглуулсан, ариутгасан, хадгалсан, лабораторийн шинжилгээнд хамруулсан, багажийн ариутгал, цэвэрлэгээ болон баталгаажуулалтын явцыг баримтжуулж тэмдэглэл хөтөлнө.

6.2. Эхийн сүүний хадгалалт, хийсэн хяналт, донор эхчүүдийн болон сүүг хэрэглэсэн хүүхдийн талаарх мэдээллийг баримтжуулж, мэдээний санг бүрдүүлнэ. Үүнд:

Бүртгэл мэдээлэл	Архивлаж хадгалах мэдээлэл
Донор эхийн мэдээлэл	• Донорын хувийн мэдээлэл • Донор эх хүүхэд төрүүлсэн тухай мэдээлэл • Төрүүлсэн нярайн эрүүл мэндийн мэдээлэл • Сайн дурын үндсэн дээр сүүгээ хандивлахыг зөвшөөрсөн гарын үсэгтэй зөвшөөрлийн хуудас

	• Халдварт өвчнөөр өвдөж байсан эсэх мэдээлэл • Серологийн шинжилгээний хариу • Хандивласан сүүний бүртгэлийн мэдээлэл, огноо
Ариутгасан багцын мэдээлэл	• Нэгтгэн боловсруулж буй сүүг хадгалах савны мэдээлэл, донорын хувийн дугаар • Пастеризацийн явц, багцийн дугаар • Пастеризацийн өмнөх эсвэл дараах микробиологийн шинжилгээний дүн • Пастеризацийн багцийн мэдээлэл: хугацаа, ариутгасан хэм (пастеризатор төхөөрөмж автоматаар бичсэн эсвэл ажилтан гараар бүртгэсэн эсэх) • Донорын сүүг хүлээн авсан салбар нэгжүүдийн бүртгэл • Шалгуурт нийцээгүй устгасан сүүний бүртгэл

6.3. Сүү хүлээн авагчийн мэдээлэл:

6.3.1. Донор эхийн сүүг хэрэглэх эмнэлгийн бичиг эсвэл эмчийн заалт гаргасан хүсэлт

6.3.2. Донор эхийн сүүг захиалсан эмнэлгийн нэр, эмчийн нэр, байршил, холбоо барих мэдээлэл

6.3.3. Хэрэглэсэн донорын сүүний талаарх мэдээлэл: огноо, цаг, хэмжээ, савны шошгон дээрх хувийн мэдээлэл, хооллолтын дараах зохистой байдал г.м.

6.3.4. Донорын сүү хэрэглэсэн нярайн нэр, төрсөн огноо, тасаг/нэгж

6.4. Мөшгөлт ба баримтжуулалт: Иж бүрэн мөшгөлт хийх, стандарт болон үйл ажиллагааны журмыг мөрдөх нөхцлийг хангах зорилгоор дараах мэдээллийг хөтөлнө. Үүнд:

1. Эхийн сүүний нөөцийн банканд хүлээн авсан сүүний бүртгэл (огноо, цагийг тэмдэглэх)
2. Хүргэлтээр ирсэн сүүний байдал (шинэ саасан, хөлдүү, гэссэн, гаднах байдал хэвийн бус)
3. Донор эхийг таних мэдээлэл (олон донорын сүү байвал бүх донорын мэдээлэл)
4. Багцын мэдээлэл
5. Сүүг хольж, хэсэгчлэн савласан огноо, цаг
6. Нэг багцад багтсан савны тоо
7. Пастеризацийн өмнөх микробиологийн шинжилгээний хариу
8. Пастеризац хийсэн сүүний хэмжээ, пастеризац хийсэн огноо, цаг
9. Пастеризацийн дараах микробиологийн шинжилгээний хариу
10. Хөлдөөгч, хөргөгчийн хэмийн өдөр тутмын бүртгэл
11. Бүх төхөөрөмжийн тохируулгын бүртгэл
12. Тоног төхөөрөмжийн явцын үзлэг, засварын бүртгэл

Эрүүл мэндийн сайдын
2025 оны . . . сарын . . . өдрийн
. . . дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

ЭХИЙН СҮҮГ САЙН ДУРААР ХАНДИВЛАХ ЗӨВШӨӨРЛИЙН ХУУДАС

(Эхийн сүү хандивлагч энэхүү баримтыг уншиж, гарын үсэг зурна)

Эхийн сүү нь нярай болон нялх хүүхдэд хамгийн тохиромжтой шим тэжээлээр баялаг хоол юм. Эхийн сүү хүүхдийн бие бялдар, мэдрэл оюуны хөгжилд чухал ач холбогдолтой бөгөөд халдварт болон халдварт бус өвчин, архаг өвчнөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах хүчин зүйлсийг агуулдаг.

Хүүхэд төрөлхийн, эсвэл түр зуурын, эсвэл эмнэлзүйн заалтаар өөрийн эхийн сүүгээр хооллож чадахгүй нөхцөлд пастеризацийн аргаар ариутгасан донор эхийн сүүг хэрэглэх нь хамгийн зөв сонголт болдог. Донорын ариутгасан сүү нь аюулгүй байдлын шаардлагыг хангасан ба сүүг удаан хугацаагаар хадгалах бодис агуулаагүй бөгөөд тодорхой хэмжээний хамгаалах хүчин зүйл, шим тэжээлийг хадгалж, дархлаа тогтолцоог дэмжиж байдаг.

Би дараах нөхцөл, шаардлагыг хүлээн зөвшөөрч байна:

1. Би 18 ба түүнээс дээш настай.
2. Би өөрийн хүүхдийн сүүний хэрэгцээг бүрэн хангаж, хангалттай байгаа тохиолдолд илүүдэл сүүгээ сайн дурын үндсэн дээр хандивлана.
3. Би эхийн сүүний банканд сүүгээ хандивлах хугацаанд эрүүл мэндийн зөв дадлыг баримтлана. Үүнд: тамхи татахгүй, архи, согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэхгүй, мансууруулах болон сэтгэц нөлөөт эм, бэлдмэл хэрэглэхгүй, эмийн хэрэглээ шаардлагатай бол эмчид болон эхийн сүүний банканд мэдээлнэ.
4. Би хандивласан эхийн сүүг батлагдсан журам, стандартын дагуу аюулгүй орчинд хадгалж, боловсруулж, лабораторийн шинжилгээнд хамруулсны дараа хүлээн авагч нярай хүүхдүүдэд түгээх боломжтойг бүрэн ойлгож, зөвшөөрч байна.
5. Би донорын сүү хандивласны төлөө ямар нэгэн төрлийн эд материал, санхүүгийн нөхөн төлбөр, урамшуулал авахгүй гэдгийг ойлгож, хүлээн зөвшөөрч байна.
6. Би өөрийн болон хүүхдийн эрүүл мэндийн шаардлагаар, өөрийн шийдвэрээр ямар ч үед сүү хандивлахаа зогсоох боломжтой бөгөөд энэ нь ямар нэгэн сөрөг үр дагавар, хязгаарлалт, хариуцлага авчрахгүйг ойлгож байна.
7. Сүү хандивлах хугацаанд эрүүл мэндийн байдалд ямар нэг асуудал гарвал би эхийн сүүний нөөцийн банкны ажилтанд даруй мэдээлж, зөвлөгөө авна. Эхийн сүүний банкны утас .....
8. Миний эрүүл мэндийн мэдээлэл, шинжилгээний хариу зэрэг миний хувийн мэдээллийг нууцалж хадгална гэдгийг би ойлгож байна.

Эхийн сүүний нөөцийн банканд хандивласан миний сүүг эмнэлэгт хэвтэн эмчлүүлж байгаа, төрсөн эхийнхээ сүүгээр хооллох боломжгүй болон эхийн сүү хангалтгүй байгаа нярайд хэрэглэхийг би зөвшөөрч байна.

Сүү хандивлах эхийн овог нэр: .....

Гарын үсэг: ....

Зөвшөөрсөн огноо: ..... оны ..... сарын ..... өдөр

Эрүүл мэндийн ажилтан .....
Донорын сургалтад хамрагдах ..... оны ..... сарын ..... өдөр
Донороор бүртгэсэн огноо: ..... оны ..... сарын ..... өдөр
Донорын хувийн дугаар .....
Сүү хандивлахыг зогсоосон огноо ..... оны ..... сарын ..... өдөр

Эрүүл мэндийн сайдын
2025 оны . . . сарын . . . өдрийн
. . . дугаар тушаалын гуравдугаар хавсралт

ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

1. Сүүгээ хандивлахыг сайн дурын үндсэн дээр зөвшөөрсөн 18 нас ба түүнээс дээш насны эхчүүдийн эхний эрсдлийн үнэлгээг дараах 4 асуултаар хийх:
    1. тамхи татдаг эсвэл никотин орлуулах эмчилгээ хийлгэж байсан эсэх;
    2. одоогоор архи, согтууруулах ундаа хэрэглэж байгаа эсэх;
    3. хар тамхи, мансууруулах бодис хэрэглэж байсан эсэх;
    4. ДОХ, гепатитын В, С вирусийн халдвар эсвэл тэмбүүгийн халдвар илэрч байсан эсэх;
2. Хэрэв дээрх 4 асуултын аль нэгэнд “Тийм” гэж хариулбал сүү хандивлах боломжгүй гэж дүгнэнэ.
3. Хэрэв дээрх 4 асуултад бүх хариулт “Үгүй” бол 12 асуулт бүхий хоёр дахь шатны эрсдлийн үнэлгээг хийх:
    1. Сүүлийн 6 сарын хугацаанд цус, цусан бүтээгдэхүүн (улаан эс, ялтас эс, сийвэн) сэлбүүлсэн эсвэл эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээ хийлгэсэн эсэх (элэг, бөөр, арьс, хөх г.м.);
    2. Гепатитын В, С вирусийн халдвар, сүрьеэ, эсвэл хорт хавдрын эмчилгээ хийлгэсэн эсэх;
    3. Одоогоор ямар нэгэн эм, уламжлалт эм тан, эмчилгээ, донтуулагч бодис, химийн бодис хэрэглэж байгаа эсэх, эсвэл цацраг идэвхт туяанд өртсөн эсэх;
    4. ХДХВ, гепатитын В, С вирус эсвэл тэмбүүгийн шинжилгээ эерэг гарч байсан эсэх;
    5. Сүүлийн 4 долоо хоногт улаанууд, улаан бурхан, гахай хавдрын эсрэг вакцинд хамрагдсан эсэх;
    6. Одоогоор тамхи татаж байгаа эсэх, эсвэл никотин орлуулагч эмчилгээ хийж байгаа эсэх (бохь, наалт, хамрын шүршигч, үнэртэгч, хэл доорх шахмал, электрон тамхи г.м.);
    7. Долоо хоногт 2 нэгжээс илүү архи хэрэглэдэг эсэх, эсвэл сүү хандивлахын өмнөх 2 цагт архи хэрэглэсэн эсэх. Жич: согтууруулах ундааны нэг нэгж нь 1/2 хундага (40%-25 мл), нэг жижиг шилтэй дарс (12%-100 мл), эсвэл нэг аяга шар айраг (5:-200 мл) болно.
    8. Хууль бус мансууруулах бодис (марихуан, кокаин, героин, экстази г.м.) эсвэл бусад хориотой бодис хэрэглэж байсан эсэх;
    9. Сүүлийн 6 сарын хугацаанд ХДХВ, гепатитын В, С вирус, тэмбүүгийн халдвар авах эрсдэлтэй хүнтэй хамгаалалтгүй бэлгийн хавьталд орсон эсэх (бэлгэвч болон бусад хамгаалалтын хэрэгсэл хэрэглээгүй);
    10. Сүүлийн 12 сарын хугацаанд нэг удаагийн бус зүү, хэрэгсэл ашиглан чих цоолох, шивээс, гоо сайхны ажилбар хийлгэсэн эсэх, эсвэл санамсаргүй зүүнд хатгуулсан эсэх;
    11. Сүүлийн 3 сард халуун орны өвчлөл ихтэй улс оронд аялсан эсэх;
    12. Хоол хүнсэндээ В аминдэмийн нэмэлтгүй хоолны дэглэм баримталдаг эсэх (В аминдэмийн нэмэлт тэжээлтэй хоолыг зөвшөөрнө);
4. Хэрэв дээрх хоёр дахь шатны асуултын аль нэг асуултад “Тийм” гэж хариулсан бол тухайн эх сүү хандивлахад тохиромжгүй гэж үзнэ.

5. Хэрэв бүх асуултад "Үгүй" гэж хариулсан бол эхийн сүү хандивлах боломжтой гэж үзнэ. Гэхдээ сүү хандивлагчийн ХДХВ, гепатитын В, С вирус, тэмбүүгийн шинжилгээ сүүлийн 6 сарын доторх хугацаанд хийгдсэн эсэх хариуг шалгана. Хэрэв шинжилгээ хийлгээд 6 сараас дээш хугацаа өнгөрсөн эсвэл шинжилгээ хийлгээгүй бол шинээр шинжилгээнд хамруулах шаардлагатай.
6. Сүүлийн 6 сарын дотор хийлгэсэн шинжилгээ эсвэл шинээр хийлгэсэн шинжилгээний хариу "сөрөг" гарсан тохиолдолд тухайн эхийг сүүний донороор бүртгэж авна.

Үнэлгээнд хамрагдсан хөхүүл эхийн овог нэр .....

Үнэлгээ хийсэн эрүүл
мэндийн ажилтны нэр.....Гарын үсэг .....

Огноо: ..... оны ..... сарын ..... өдөр

НОМ ЗҮЙ

1. Эхийн сүүний банк байгуулах, ажиллуулах техникийн удирдамж, Вьетнам Улс, 2021 он (The Technical Guideline for Establishing and Operating Human Milk Banks, Vietnam, 2021)
2. Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын Эхийн сүүний банкны удирдамж (WHO Donor Human Milk Banking Guidelines)
3. PATH: Эхийн сүүний банкыг бэхжүүлэх: Эхийн сүүний банкны хөтөлбөрүүд хэрэгжүүлэх, нэгтгэж уялдуулах – Дэлхийн хэрэгжилтийн хүрээ, Хувилбар 2.0 (PATH: Strengthening Human Milk Banking: A resource toolkit for Establishing and Integrating Human milk bank programs Global Implementation Framework Version 2.0)
4. Зүүн Өмнөд Азийн бүс нутагт Эхийн сүүний банк байгуулах, ажиллуулах суурь стандартууд (Minimum Standards for the Establishment and Operation of Human Milk Banks in Southeast Asia)
5. Филиппинь Улсын “Эхийн сүүний банк”: Үйл ажиллагааны гарын авлага (The Philippine Human Milk Banking: Manual of Operation)

ТОВЧИЛСОН ҮГС

ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ДЭМБ	Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага
НЭМГ	Нийслэлийн эрүүл мэндийн газар
НЭМҮТ	Нийгмийн эрүүл мэндийн төв
ЭХЭМҮТ	Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв
ОУБ	Олон улсын байгууллага
ӨЭМТ	Өрхийн эрүүл мэндийн төв
ХДХВ	Хүний дархлал хомсдолын вирус